



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот


### **Хэлтэс, төвийн үйл ажиллагааг сурталчилах тухай**

Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1."Эрүүл мэндийн газрын хэлтэс, төвийн үйл ажиллагааг сурталчилах ажлын удирдамж"-ийг нэгдүгээр, "Хэлтэс, төвийн үйл ажиллагааг сурталчилах хуваарь"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалыг мөрдөж ажиллахыг хэлтэс, төвийн дарга нар, нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Ц.Хун), Эмийн асуудал эрхэлсэн дэд дарга (М.Уранчимэг) –д даалгасугай.

ДАРГА  Ш.ЭНХБАТ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын даргын 2012 оны 3 дугаар сарын 26 ны өдрийн 4 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



### **Эрүүл мэндийн газрын хэлтэс, төвийн үйл ажиллагааг сурталчилах ажлын удирдамж**

**Зорилго:** Хэлтэс, төвийн үйл ажиллагааг сурталчилж, байгууллагын үйл ажиллагааны шуурхай, нээлттэй байдлыг дээшлүүлэх.

**Хугацаа:** 2012 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 10 дугаар сарын 06-ны хооронд батлагдсан хуваарийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.

#### **Гүйцэтгэх ажил:**

- Хэлтэс, төвийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн боломжтой олон арга хэлбэрээр сурталчилах талаар төлөвлөгөө боловсруулж батлуулах;
- Хэлтэс, төвийн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, дүрэм, журмыг сурталчилж, таниулах;
- Үйл ажиллагааны шуурхай, ил тод, нээлттэй байдлыг хангах талаар шинэ санал, санаачилга гарган хэрэгжүүлэх;
- Байгууллагын вэб хуудас, мэдээллийн дэлгэц, самбарын ашиглалтыг сайжруулах, шинэ мэдээ, мэдээллийг цаг тухайд нь байрлуулж, шинэчлэх;
- Хамтран ажиллагч байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан уулзалт зохион байгуулах;
- Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах;
- Байгууллагын дотор өөрийн үйл ажиллагааг бусад хэлтэс, төвийн албан хаагчдад таниулж, сурталчилах;
- Байгууллага доторх хэлтэс, төвийн ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр санаачилга гарган хэрэгжүүлэх;

**Хариуцах эзэн:** Бүх хэлтэс, төв

**Хүрэх үр дүн:** Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй, шуурхай байдал сайжирч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ.

**Хэлтэс төвийн үйл ажиллагааг сурталчилах хуваарь**

| № | Хэлтэс, төвийн нэр                                | Хугацаа         |                 |                |               |                |                 |                  |                 |                |
|---|---|-----------------|-----------------|----------------|---------------|----------------|-----------------|------------------|-----------------|----------------|
|   |   | IV.02-<br>IV.14 | IV.16-<br>IV.28 | IV.30-<br>V.12 | V.14-<br>V.26 | V.28-<br>VI.09 | VI.11-<br>VI.23 | VI.25-<br>VII.07 | IX.10-<br>IX.22 | IX.24-<br>X.06 |
| 1 | Эмнэлгийн техник, технологи, эдийн засгийн хэлтэс |                 |                 |                |               |                |                 | ////////         |                 |                |
| 2 | Эмнэлгийн тусламжийн хэлтэс                       |                 |                 |                |               |                | ////////        |                  |                 |                |
| 3 | Эрүүл мэндийн статистикийн хэлтэс                 |                 |                 | ////////       |               |                |                 |                  |                 |                |
| 4 | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн хэлтэс            |                 | ////////        |                |               |                |                 |                  |                 |                |
| 5 | Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс                     |                 |                 |                | ////////      |                |                 |                  |                 |                |
| 6 | Эмийн зохицуулалтын хэлтэс                        | ////////        |                 |                |               |                |                 |                  |                 |                |
| 7 | Захиргаа, санхүүгийн хэлтэс                       |                 |                 |                |               |                |                 |                  |                 | ////////       |
| 8 | Телемедициний үндэсний сүлжээний төв              |                 |                 |                |               |                |                 |                  | ////////        |                |
| 9 | Түргэн тусламжийн үндэсний сүлжээний төв          |                 |                 |                |               | ////////       |                 |                  |                 |                |